# ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
# 2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
# ХИЙСЭН САЙНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## Агуулга


1. Аудитын гэрчилгээ ..... 2
2. Аудитын тайлан ..... 4
   2.1 Оршил ..... 4
   2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ..... 4
   2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ..... 4
   2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ..... 5
   2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ..... 6
   2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ..... 6
   2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ..... 6
   2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ..... 7
      2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал ..... 7
   2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ..... 8
   2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ..... 8
   2.11 Шилэн дансны мэдээлэл ..... 8
   2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга ..... 8
   2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ..... 9
3. Менежмент ийн захидал ..... 10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан ..... 12
   4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 12
   4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 14
   4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 16
   4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 18
   4.5 Төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 19
   4.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан ..... 22
5. Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт ..... 23


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |
| АОУС | Аудитын олон улсын стандарт |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/250
танай ____________-ны № ____________-т

СЭРГЭЭН ЗАСАЛТ, СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН ДАРГА Ч.ГАНБОЛД ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдалд, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, заврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын үр дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

УХА№122

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2019\0225SAG12.Docx

## 2. Аудитын тайлан

### 2.1 Оршил

Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн дарга Ч.Ганболд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 11 дүгээр сарын 15-наас 2019 оны 02 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж,Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Өлзийт экаунт аудит ХХК-ын аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв нь 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өлзийт экаунт аудит ХХК-д 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/23 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

**2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, A101 маягтаар баталгаажуулсан болно.

**Эрхэм зорилго:**

Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв нь “Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хангах, бие даан хөгжих чадварыг эзэмшүүлэх, амьдралын чанарыг сайжруулахад оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

**Үйл ажиллагааны чиглэл:**

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 55 дугаар тогтоолоор Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх
- Сэргээн засах эмнэлэг, мэргэжлийн боловсрол  ур чадвар олгох сургалт зохион байгуулах
- Протез,ортопедийн үйлдвэрийг эрхлэх

Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль
- Татварын багц хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

**2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “ACOULOS” програм хангамж ашигладаг.

Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

**2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 12 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

**2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлын 2 хувиар сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын дүнгээр сонгоход материаллаг түвшин бага байсан тул төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын суурийг үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээр сонгосон.

Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,032,707.8 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 86,414.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтийг 1 хувиар тооцоход ажил гүйлгээний тоо, цар хүрээ их, ажил гүйлгээний мөнгөн дүн бага, эрсдэл багатай тул суурь үзүүлэлтийг 2 хувиар тооцох нь зүйтэй гэж үзсэн.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

**2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 19 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 9 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

- Тавилга, эд хогшил дансны элэгдлийг 107.3 мянган төгрөгөөр илүү тооцсон.
- Үндсэн үйл ажиллагааны орлогыг санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны бус орлого хэсэгт мянган төгрөг тайлагнасныг үндсэн үйл ажиллагааны орлогод бүртгэн тайлагнасан.
- Харьяа дүүргийн татварын хэлтэстэй 32.0 мянган төгрөгийн авлагын тооцоо нийлж баталгаажуулсан боловч санхүүгийн тайланд авлагаар тусгаагүйг залруулсан.
- Тусгай зориулалтын бараа материал буюу протез ортопед худалдан авах тендерийн шалгуур үзүүлэлтээ хэт өндөр тогтоосон.
- Нэмэлт санхүүжилтийн данснаас олгосон 440.0 мянган төгрөгийн цалин хөлснөөс 81.8 мянган төгрөгийн Нийгмийн даатгалын шимтгэл суутгалгүй шууд олгосон.
- Тайлант оны төсвийн санхүүжилтийн хүндрэлээс шалтгаалан Сүхбаатар Дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст 32,007.3 мянган төгрөг, Үйлдвэрчний эвлэлд 1,586.7 мянган төгрөг нийт 33,594.1 мянган төгрөгийн өртэй тайлагнагдсан.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

/мянган төгрөгөөр/

| № | Шийдэл | Тоо | Дүн | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Зөвлөмж өгсөн | 3 | 49,222.3 | Авлага,УОО үлдэгдлийн баталгаа болон зардлын ангилал зөрүүлсэн. |
| **2** | Албан шаардлага | 1 | 6,600.0 | Өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй. |
| | Дүн | 4 | 55,822.3 | |

<u>2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал</u>

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Өмнөх оны санхүүгийн тайлангийн 1 зөвлөмжийг биелүүлээгүй байна. Тус төв нь 2015 онд ШШГЕГ-тай хөгжлийн бэрхшээлтэй хүмүүжигч хоригдлуудад хиймэл эд эрхтэн нийлүүлэх 6,600.0 мянган төгрөгийн гэрээ хийн нийлүүлснээс үүссэн авлагыг барагдуулах зөвлөмжийг биелүүлж ажиллаагүй байна.

**2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2018 оны санхүү тайлангийн аудитын явцад гүйцээж, мөшгөн шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

**2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 2,120,460.0 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын гүйцэтгэл нь 2,007,465.7 мянган төгрөг буюу 94.7 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь эрүүл мэндийн даатгалын сангаас 134,518.6 мянган төгрөгийг дутуу санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

**2.11 Шилэн дансны мэдээлэл**

Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Энэхүү үүргийн хүрээнд тус төв нь 2018 оны 01 дүгээр сараас 12 дугаар сарын байдлаар нийт 132 ширхэг ил тодын мэдээ байршуулсан ба үүнээс 99 мэдээллийг хугацаандаа байршуулсан байна. Сар болгон батлагдсан орон тоо түүний өөрчлөлт, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр арга хэмжээ, гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн талаар тогтмол мэдээлдэг байна. Харин цаг үетэй холбоотой 8 төрлийн мэдээллийг өөрчлөлт оруулах тухай бүр мэдээлжээ.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

**2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 75 хувьтай байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4 зөвлөмж хүргүүлснээс 3 зөвлөмжийг биелүүлж, 1 зөвлөмжийг биелүүлээгүй байна. Тус төв нь 2015 онд ШШГЕГ-тай хөгжлийн бэрхшээлтэй хүмүүжигч хоригдлуудад хиймэл эд эрхтэн нийлүүлэх 6,600.0 мянган төгрөгийн гэрээ хийн нийлүүлснээс үүссэн авлагыг барагдуулах зөвлөмжийг биелүүлээгүй байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

**2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

## 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. **Үүнд:**

**1. Балансын данстай холбоотой асуудал**

1.1 Илрүүлэлт:

Урьдчилж орсон орлогын 9,270.1 мянган төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь эрх ба үүрэг, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах гэж заасныг тус тус зөрчсөн байна.

1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан Урьдчилж орсон орлого дансны үлдэгдлийн дүн үнэн зөв баталгаажаагүй байх.

1.3 Өгсөн зөвлөмж:

Урьдчилж орсон орлогын үлдэгдлээ тооцоо нийлж баталгаажуулж байх.

1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Урьдчилж орсон орлогын үлдэгдлээ тулган баталгаажуулна. Алслагдсан аймагтай холбогдон баталгаажуулах ажил хийнэ.

**2. Зардлын данстай холбоотой асуудал**

2.1 Илрүүлэлт:

БҮТЭЗ-ийн зардлын дансанд 7,194.3 мянган төгрөгийн зардлыг ангилал зөрүүлэн тайлагнасан байсан нь толилуулга ба тодруулга болон хэмжилт батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5–д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг зөрчсөн байна.

2.2 Эрсдэл:

Зардлыг ангиллын дагуу бүртгэхгүй байх.

2.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай 2014 оны 55 тоот тушаалын дагуу Төсвийн зарлагыг эдийн засгийн ангилалын дагуу тайлагнах.

2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зардлыг эдийн засгийн ангиллын дагуу бүртгэж ажиллана.

**3. Балансын данстай холбоотой асуудал**

3.1 Илрүүлэлт:

Тайланд онд 32,757.9 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байгаа нь оршин байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д зааснаар “Төсвийг зохистой удирдаж авлага, өглөг үүсгэхгүй байх” заалтыг зөрчсөн байна.

3.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан авлага найдваргүй болох.

3.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасныг баримтлан авлагаа барагдуулан, үлдэгдэлгүй ажиллах.

3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Авлага барагдуулах арга хэмжээ авч ажиллахад анхаарна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **509,068,458.86** | **452,950,765.89** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 268,239.00 | 492,019.00 |
| **311** | **Кассанд байгаа бэлэн мөнгө** | 258,239.00 | 491,075.00 |
| 31110 | Төгрөг | 258,239.00 | 491,075.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 10,000.00 | 944.00 |
| **3121** | **Төгрөг** | 10,000.00 | 944.00 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 10,000.00 | 944.00 |
| **33** | **АВЛАГА** | **66,313,341.00** | **9,073,415.00** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 2,441,400.00 | 2,441,400.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 6,600,000.00 | 6,600,000.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 57,271,940.00 | 00.00 |
| **335** | **Бусад авлага** | 01.00 | 32,015.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 01.00 | 32,015.00 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | **24,576,550.00** | **23,716,550.00** |
| **3471** | **Урьдчилгаа тооцоо** | 24,576,550.00 | 23,716,550.00 |
| 34711 | Бараа материал бэлтгэх урьдчилгаа | 24,576,550.00 | 23,716,550.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **417,910,328.86** | **419,668,781.89** |
| **351** | **Түүхий эд материал** | 265,251,502.07 | 277,584,894.31 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 213,049,755.65 | 254,100,486.75 |
| 35130 | Эм боох материал | 40,528,977.42 | 14,431,995.56 |
| 35200 | Дуусаагүй үйлдвэрлэл | 6,914,320.00 | 8,117,080.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 4,758,449.00 | 935,332.00 |
| **354** | **Хангамжийн материал** | **152,658,826.79** | **142,083,887.58** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 7,301,050.00 | 7,159,850.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,337,831.74 | 144,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 144,019,945.05 | 134,780,037.58 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,900,048,763.97** | **3,726,918,957.74** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 4,900,048,763.97 | 3,726,918,957.74 |
| 391 | Газар | 00.00 | 56,665,000.00 |
| **392** | **Биет хөрөнгө** | **4,900,048,763.97** | **3,670,253,957.74** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 3,123,195,529.00 | 2,009,464,064.01 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -623,625,298.99 | 00.00 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 192,045,902.23 | 192,045,902.23 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -112,141,696.14 | -142,404,205.98 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 3,953,141,196.41 | 3,900,729,943.65 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -1,773,541,049.47 | -2,398,807,697.88 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 241,294,158.94 | 213,377,407.84 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -100,389,978.01 | -104,221,456.13 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 2,217,200.00 | 00.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -2,217,200.00 | 00.00 |
| 39217 | Ном | 70,000.00 | 70,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 00.00 | 00.00 |
| 39301 | Програм хангамж | 935,000.00 | 935,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -935,000.00 | -935,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **5,409,117,222.83** | **4,179,869,723.63** |

| | | | |
|---|---|---|---|
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **49,076,614.80** | **147,161,895.34** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 49,076,614.80 | 147,161,895.34 |
| **413** | **Өглөг** | 15,049,705.00 | 99,470,017.15 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 0.00 | 33,594,111.43 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 0.00 | 52,133,305.72 |
| **4136** | **Бусад өглөг** | 15,049,705.00 | 13,742,600.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 05.00 | 00.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 15,049,700.00 | 13,742,600.00 |
| **414** | **Урьдчилж орсон орлого** | 34,026,909.80 | 47,691,878.19 |
| 41440 | Бусад урьдчилж орсон орлого | 34,026,909.80 | 47,691,878.19 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **5,360,040,608.03** | **4,032,707,828.29** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 5,360,040,608.03 | 4,032,707,828.29 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,910,706,267.63 | 1,910,706,267.63 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,910,706,267.63 | 1,910,706,267.63 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 3,199,527,494.25 | 899,589,357.06 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 3,199,527,494.25 | 3,199,527,494.25 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -2,299,938,137.19 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 249,806,846.15 | 1,222,412,203.60 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **5,409,117,222.83** | **4,179,869,723.63** |

### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | **2,268,189,548.00** | **2,020,779,915.40** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | **239,260,755.00** | **148,695,186.40** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | **239,260,755.00** | **148,695,186.40** |
